



Эрүүл хүнс - Таны сонголт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020

НЭГДҮГЭЭР ХАГАС



- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

АГУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

- Компанийн түүхэн товчоо
- Эрхэм зорилго, Үнэт зүйл
- Ажиллах хүчний нөөц

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Хураангуй тойм





1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ



- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

КОМПАНИЙН ТҮҮХЭН ТОВЧОО



БИДНИЙ ТҮҮХ

ҮЙЛДВЭРЛЭЖ БАЙГАА ТАЛХНЫ 50 ХУВИЙГ
ХӨХ ТАРИАНЫ ОЛОН ҮРТЭЙ ТАЛХ ЭЗЭЛДЭГ



1984 он "Талх чихрийн комбинат" нэртэйгээр ашиглалтанд орж талх 90 тонн, Чихэр 5000 тонн, Жигнэмэг, Өрмөнцөр, бялуу 6550 тонн, Жимсний чанамал 800 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэв.

1999 он "Талх чихэр" ХК болон хувьчлагдав.

2003 он БНСУ-ын Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх хөргүүртэй, хөргүүргүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, Тайвань улсын сахарын болон хатуу төрлийн жигнэмэгийн шугам ашиглалтанд оров

2004 он Микробиологи, Химийн лабораторид шинэчлэл хийж, дугуй талх үйлдвэрлэх компьютерын удирдлагатай иж бүрэн шугам ашиглалтанд оров.

2006 он Монгол улсдаа анх удаа зүссэн талхыг хэрэглэгчдэд хүргэв.

2008 он Герман, Украин улсуудад-Гурил шуудайгүйгээр тээвэрлэх тоног төхөөрөмжийг захиалгаар хийлгэв

2010 он БНЧУ, Голланд Нарийн боовны үйлдвэрлэлийн техник технологийг иж бүрэн шинэчилсэн

2010 он "Тачи", "Органик" брэндийн нарийн боов худалдаанд гарав.

2012 он "Та Чи" 4 төрлийн баяжуулсан талхны урсгал шугам суурилуулав.

2013 он Талхны анхны бүрэн автомат савлагааны машин суурилуулав.

2013 он Дархан, Эрдэнэт хотуудад борлуулалтын баг томилон ажиллуулж анхны түгээлтээ хийв.

2014 он Монгол улсдаа анх удаа чаналгын бүтээгдэхүүний тос шүүгч бүрэн автомат урсгал шугамыг Итали улсын СЕРІ, CANOL, TECHNO-D, ЧЕХ улсын TOPOS фирмүүдэд захиалгаар үйлдвэрлүүлэв.

2014 он "Фрэнч баггет" брэндийг үйлдвэрлэж эхлэв.

2015 он Бородино, Сэндвич, Бургер талхыг үйлдвэрлэж эхлэв.

2016 он Талх, нарийн боовны үйлдвэрт тус бүр 30.000м³ бүрэн автомат агааржуулалтын системийг суурилуулав.

2017 он Азидаа анх удаа БНЧех улсын J4 компанийн хоёр давхар пийшинтэй талхны иж бүрдэл урсгал шугам ашиглалтанд оруулсан, Итали улсын СЕРІ компаниас 500тн гурил вакум орчинд хадгалах, дамжуулах зориулалт бүхий иж бүрэн системийг угсарч суурилуулав.

2018 он Талх 30 нэр төрөл, нарийн боов 35 нэр төрөл, бялуу болон бэйкери 60-н нэр төрөл, 10 гаруй нэр төрлийн жигнэмэг тус үйлдвэрлэж өдөр тутам Улаанбаатар хотын 3200 гаруй цэгт түгээлт хийж 500.000 өрхийг талх нарийн боовоор өдөр тутам хангаж байна.



- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -



Эрхэм зорилго

Бид олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэт технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хэрэглэгч харилцагчдынхаа сэтгэл ханамжинд үнэлэгдсэн хүнсний салбарын загвар компани байна.

Алсын хараа

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна.

Үнэт зүйлс

- Т - Тэргүүн технологи
- А - Аюулгүй бүтээгдэхүүн
- Ч - Чадварлаг ажилтан
- И - Итгэлцэл, түншлэл





- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -


КОМПАНИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НӨӨЦ



Нийт ажилтан

812

 **43,6%**
Male


 **56,4 %**
Female

Хөгжлийн бэрхшээлтэй



32

Нийт ажилтан насаар



Нийт ажилтан боловсрол



34.8% Дээд боловсролтой



6.9% Дунд боловсролтой



47.9% Бүрэн дунд боловсролтой



9.7% Тусгай дунд боловсролтой





2. 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ / ХАГАС ЖИЛИЙН /

Нийт **812** ажилтантайгаар **100 гаруй** нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, борлуулж 28.8тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Ажилчид болон тэдний ар гэрийнхэнд зориулсан нийгмийн халамжийн үйл ажиллагааг үе шаттайгаар хийж хэрэгжүүлсэн. Үүнд Нийт ажилчдын дархлаажуулалтын хөтөлбөр мөн ажилчдад хямралыг хамтдаа давцгаая хөтөлбөр гэх мэт маш олон нийгмийн халамжийн үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлсэн нь ажилчдын ажилдаа сэтгэл ханамжтай ажиллах, хүнд хэцүү цагийг ажралгүй даван туулах хүч болсон юм.

Цаг үеийн байдлаар өндөржүүлсэн бэлэн байдал зарлан үйлдвэрлэлийн орчин түүний халдваргүйжүүлэлт, тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ, ажилчдын эрүүл мэндийн үзлэг шалгалтуудыг тогтмол үе шаттайгаар хийж хэрэгжүүлэн ажилласан нь тухайн цаг үед ямар нэгэн эрсдэл учруулалгүйгээр тасралтгүй үйлдвэрлэл явуулах үндэс болсон юм. Мөн үйлдвэр гаднаас зочин хүлээн авахгүй зөвхөн ажилтан алба хаагчид өндөр шалгалт дор нэвтэрч байгаа явдал нь ямар ч нөхцөлд болзошгүй аюулаас хамгаалж байгаа юм.

2020 эхний хагас жилд Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад зориулан цахим худалдаа хийх боломж бүхий платформын хөгжүүлэлтийг эхлүүлэн ажиллаж байна. Мөн 3 төрөл зүйлийн шинэ бүтээгдэхүүн 1 брэндийг зах зээлд нийлүүлэн ажиллаж байна.



- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

2020 ОНЫ ЗОРИЛТ



- 1. Компаний хэмжээнд нийт ажилчдаа мэргэшүүлэх, гадаад болон дотоодын тэмцээн уралдаанд оролцох, ур чадвараа нэмэгдүүлэх сургалт семинарт хамруулах. Ингэснээр мэргэжлийн ажилтны тогтвор суурьшилийг нэмэгдүүлэх**
- 2. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн шинэ бодлого баримталж дэлхийн стандартад нийцсэн олон улсын зах зээл дээр худалдаалагдаж байгаа бүтээгдэхүүнийг эх орондоо нутагшуулах, шинэ хэрэглээний соёл бий болгох**
- 3. Харилцагч, хэрэглэгчидтэй харилцах бодлогод сайжруулалт хийх, цахим худалдааны үйлчилгээг нэвтрүүлэх**





ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮА ХҮНС **1984** ТАНЬ СОНГОЛТ
ОНООС



3. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА





- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Компаний хэмжээнд нийт ажилчдаа мэргэшүүлэх, гадаад болон дотоодын тэмцээн уралдаанд оролцох, ур чадвараа нэмэгдүүлэх сургалт семинарт хамруулах. Ингэснээр мэргэжлийн ажилтны тогтвор суурьшилийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд хийгдсэн ажил

1. Дэлхийн хэмжээний цар тахал COVID-19-ийн үед 2020 оны тавьсан нэгдүгээр зорилтын хүрээнд хийгдсэн ажлууд

- Ажилчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг дотоод нөөц бололцоогоор тогтмол хийж хэрэгжүүлж байв. / Борлуулалтын ажилтан, менежерүүд, Үйлдвэрийн ажилчид, харилцагчид /
- Ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогын хүрээнд оны эхнээс ажилчдад чиглэсэн үйл ажиллагааг тогтмол явуулсан.
“Дархлаа дэмжих хөтөлбөр” мөн “Хямралыг хамтдаа давцгаая” хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.



- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн шинэ бодлого баримталж дэлхийн стандартад нийцсэн олон улсын зах зээл дээр худалдаалагдаж байгаа бүтээгдэхүүнийг эх орондоо нутагшуулах, шинэ хэрэглээний соёл бий болгох зорилгын хүрээнд хийгдэж буй ажил

2. Олон улсын стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг цаг алдалгүй хэрэглэгчиддээ хүргэж байна.

- Хаан Брэндийн бургер, хотдогны талхыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Тухайн брэнд цаг үеэ олсон брэнд байсан бөгөөд хэдийнээ хэрэглэгч худалдан авагчдын худалдан авах дуртай бүтээгдэхүүний нэг болсон байна.
- Монголчуудын өв уламжлал цагаан идээ тэр дундаа шар тос, өрөм цөгций, бурмын шанз бүхий 3 төрлийн нарийн боов үйлдвэрлэн хэрэглэгчддээ танилцуулаад байна.
- Мөн Хотол үйлдвэрийн хэрэглэгч нарт зориулан хушгатай кекс бүтээгдэхүүнийг хэрэглэгчид зориулан худалдаанд гаргах ажил хийгдэж байна.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2. Олон улсын стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг цаг алдалгүй хэрэглэгчиддээ хүргэж байна.

- Хаан Брэндийн бургер, хотдогны талхыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Тухайн брэнд цаг үеэ олсон брэнд байсан бөгөөд хэдийнээ хэрэглэгч худалдан авагчдын худалдан авах дуртай бүтээгдэхүүний нэг болсон байна.
- Уг брэнд нь COVID-19 өвчний онц байдлын үед хэрэглэгч үйлчлүүлэгч нартаа зориулан Мах Импэкс ХК-тай хамтран гаргасан брэнд юм.

Арвайн шанзтай гэвэн

ОРЦ НАЙРЛАГА: Буудайн гурил БГ-055
Арвайн гурил
Элсэн чихэр
Шар тос
Маргарин 82%
Долдуу тос
Шингэн сүү
Какао нунтаг
Давс
Хүнсний сод

ДАВУУ ТАЛ: АРВАЙН ГУРИЛ нь амин дэм уураг, нүүрс үс болон эслэг их агуулдаг бол ШАР ТОС нь витамин А. Агуулахаас гадна хий дарж тамир тэнхээ сайжруулах, арьсны нөхөн төлжилтийг түргэсгэдэг. Эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх тус бүтээгдэхүүн нь онцгой сайхан амт үнэртэй.

Хадгалах хугацаа 14 хоног



Шар тостой гэвэн

ОРЦ НАЙРЛАГА: Буудайн гурил БГ-055
Элсэн чихэр
Шар тос
Долдуу тос
Давс
Хүнсний сод

ДАВУУ ТАЛ: ШАР ТОСНЫ баялаг орцтой учраас өөг мэдрэмжийг төрүүлэх тус бүтээгдэхүүн нь шинэлэг байдлаа удаан хадгалдаг. Аялал зугаалганд авч явахад тохиромжтойгоос гадна өдөр бүр сүү, сүүтэй цайтай хослуулан хэрэглэхэд эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө.

Хадгалах хугацаа 21 хоног



Амтат жигнэмэг

ОРЦ НАЙРЛАГА: Буудайн гурил БГ-055
Элсэн чихэр
Маргарин
Нойтон өндөг
Ванилын нунтаг
Хүнсний сод

ДАВУУ ТАЛ: Зөөлөн бутрамтгай шинжийг агуулах АМТАТ ЖИГНЭМЭГ нь аль ч насныхан хэрэглэхэд тохиромжтой. Баялаг орцтой тул өглөө, өдөр, оройн цайнд жүүс болон цай, кофетой хослуулан хэрэглээрэй.

Хадгалах хугацаа 21 хоног



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2. Олон улсын стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг цаг алдагүй хэрэглэгчиддээ хүргэж байна.

- Монголчуудын өв уламжлал цагаан идээ тэр дундаа шар тос, өрөм цөгций, бурам оросон шанз бүхий 3 төрлийн нарийн боов үйлдвэрлэн хэрэглэгчддээ танилцуулаад байна.

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Харилцагч, хэрэглэгчидтэй харилцах бодлогод сайжруулалт хийх, цахим худалдааны үйлчилгээг нэвтрүүлэх зорилгын хүрээнд хийгдэж буй ажил

3. Хэрэглэгчиддээ улам ойртох, чанар стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг цаг алдалгүй хүргэх гэсэн зорилго тавин шинэ үйлчилгээг хөгжүүлж байна.

Захиалга хүргэлтэд суурилсан хэрэглэгчидэд туслах төвийг ашиглалтанд оруулахаар бэлдэж байна.






- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

COVID-19 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Дэлхийн хэмжээний цар тахал COVID-19-ийн үед “Талх Чихэр” ХК хамт олон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол хийж хэрэгжүүлэн өндөржүүлсэн бэлэн байдал дор ажиллаж байна.

- Борлуулалтын машины ариутгал тогтмол хийж түр цэгээр дамжуулан үйлдвэрээс гарах болон орох хөдөлгөөний байнга хянаж байна.
- Нийт ажилчдад тогтмол амны хаалт тарааж амны хаалт зүүх, солих, ашиглах хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, ажилд гарах үед халуун болон биеийн нөхцөл байдлыг шалгаж үзээд шаардлагад нийцсэн тохиолдолд ажилд нь оруулж байна.
- Компанийн хэмжээний ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.





ТАЛХ ЧИХЭР ХК
1984

БНХАУ-ААС АНХ ИЛЭРЧ ОЛОН УЛСАД
ДЭГДЭЭД БАЙГАА **КОРОНАВИРУС** ХҮНИЙ
ЭРҮҮЛ МЭНДЭД НОЦТОЙ ХОХИРОЛ
УЧРУУЛААД БАЙНА. ИЙМД "ТАЛХ ЧИХЭР"
ХК-ИЙН ЗҮГЭЭС НИЙТ АЖИЛЧДАА ЭРҮҮЛ
МЭНДИЙН ҮЗЛЭГТ ТОГТМОЛ ХАМРУУЛАН
МЭДЭЭЛЭЛ. СУРГАЛТААР ХАНГАН АЖИЛЛАЖ
БАЙНА.

**2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН
2-НЫГ ХҮРТЭЛ** ГАДНЫ ХҮМҮҮСИЙГ
ДОТОГШ НЭВТРҮҮЛЭХГҮЙ БОЛОХЫГ
АНХААРНА УУ.

ТАЛХ ЧИХЭР ХК
1984

МЭДЭГДЭЛ

НИЙГЭМД ЦОЧРОЛ ҮҮСГЭЭД БАЙГАА КОРОНАВИРУСТЭЙ
ХОЛБООТойгоор ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУНД ХҮНСНИЙ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТ ЗОХИОМЛООР ҮҮСЭЭД БАЙНА.
ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭГЧ
"ТАЛХ ЧИХЭР" ХК-ИЙН ХУВЬД ХАНГАЛТАЙ НӨӨЦТЭЙ ТҮЛ
ҮЙЛДВЭРЭЭ ТОГТВОРТОЙ АЖИЛЛУУЛЖ
ТААХ, НАРИЙН БООВ, ГУРИААН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЗАХ ЗЭЭЛД
ТАСРАЛТГҮЙ НИЙЛҮҮЛЭХ БОЛОМЖТОЙГООС ГАДНА
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭЭ НЭМЭХГҮЙ БОЛОХЫГ
АЛБАН ЁСООР МЭДЭГДЭЖ БАЙНА.



ТАЛХ ЧИХЭР ХК

1984
ОНООС

САНХҮҮГИЙН ТАЙЛАН



- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

2020 ОНЫ САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТОЙМ



Д/Д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2019	2020	ЗӨРҮҮ	ХУВЬ
1	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	25319,5	28848,4	3528,9	12,3%
2	БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	19221,7	21,927,3	2715,6	14,1%
3	НИЙТ АШИГ АЛДАГДАЛ	6107,7	6921,0	813,38	13,3%
4	БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ	324,2	228,8	-74,1	-29,5%
5	ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ	4490,7	5325,0	834,3	18,5%
6	БУСАД ЗАРДАЛ	282,6	236,5	-46,1	-19,4%
7	БУСАД АШИГ АЛДАГДАЛ	/-157,8/	/-198,5/	40,7	25,7%
8	ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ	852,2	931,1	78,9	9,2%
9	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	101,0	112,9	11,9	11,7%
10	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ	751,1	818,2	67,1	8,9%
11	ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ	751,1	818,2	67,1	8,9%
12	АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН	75,8	76,0	0,2	0,01%



- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -



“Талх Чихэр”ХК энэ хэцүү цаг үед үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой чигээр хадгалж ажиллах хүчний орон тоог нэмэгдүүлэн орон тооны цомхтгол хийлгүй амжилттай ажиллаж байна.
Энэ амжилт нь 800 гаруй ажилтны хамтын хөдөлмөрийн үнэ цэнэ юм.





- 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -



АНХААРАЛ ТАВЬСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА

